



БОАЖА-НЫ
ОЗОНЫ ҮНДЭСНИЙ АЛБА



United Nations
Environment Programme

НҮБ-ЫН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ХӨТӨЛБӨР


ТА ОЗОНЫ ДАВХАРГАД ХЭРХЭН ТУСАЛЖ ЧАДАХ ВЭ?



Улаанбаатар хот
2020 он

ТА ОЗОНЫ ДАВХАРГАД ХЭРХЭН ТУСАЛЖ ЧАДАХ ВЭ?

Агаар мандлын дээд хэсэгт байх озоны давхарга нь Та биднийг Нарны гэрлийн хэт ягаан туяанаас учрах хор хөнөөлөөс хамгаалах бамбай болдог. Иймд Та бид озоны давхаргаа хамгаалахын тулд юу хийж чадах вэ?



“Озоны давхаргад ээлтэй байна” гэдэг нь таны худалдан авч байгаа бараа бүтээгдэхүүн, танай гэр бүл, бизнесийн хэрэглэж байгаа гэр ахуйн хэрэгсэл, тоног төхөөрөмж, танай



компанийн үйлдвэрлэлийн процесс зэргээс үүдэлтэй, давхраат мандлын озон давхрагад үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгахад хүн бүр хийж чадах зүйл юм. CFC, HCF-С, HFC, галон, метилхлор, метилбромид зэрэг озон задалдаг бодисоор хийсэн буюу түүнийг агуулсан бараа бүтээгдэхүүн озон давхаргыг хомсдоход гол нөлөө үзүүлдэг.

ТА ОЗОНД ХАЛГҮЙ ХЭРЭГЛЭГЧ БАЙЖ ЧАДНА

Озонд халгүй, эсвэл ОЗБ-гүй гэсэн шошготой бүтээгдэхүүнийг /хөргөгч, хөлдөөгч, агаар сэлгүүр, шүршигч, гал унтраагуур гэх мэт/ худалдаж авч байгаарай. Бараа бүтээгдэхүүний шошгон дээр CFC, галон зэрэг ОЗБ-ыг агуулаагүй гэдгийг харж болно. Тухайн худалдан авч буй бараа бүтээгдэхүүн озоны давхаргад халгүй болохыг мэдэхийн тулд худалдагчаас сайтар асууж бай. Озонд халгүй бараа бүтээгдэхүүний эзэн гэдгээрээ Та бахархдагаа хөршдөө хэлж болно шүү дээ.



ТА ОЗОНД ХАЛГҮЙ ГЭРИЙН ЭЗЭН, ЭЗЭГТЭЙ БАЙЖ ЧАДНА

Хуучин хөргөгч, гэр ахуйн хэрэгсэлээсээ ухамсраараа татгалзаж сур. Хөргөгчөө хаяхаасаа өмнө CFC, HCFC, HFC, хөргөх бодисыг хөргөгчөөс гаргаж юүлж авах хэрэгтэй.



Мөн ашиглахгүй зөөврийн гал унтраагуураа гал түймэртэй тэмцэх газарт дахин цэнэглүүлэх хэрэгтэй. Галын ажилтны санал болгосон галон агуулаагүй шинэ төрлийн гал унтраагуурыг худалдан авах талаар бодоорой.

ТА ОЗОНД ХАЛГҮЙ ТАРИАЛАНЧ БАЙЖ ЧАДНА

Хэрэв та газар тариаландаа метилбромид ашигладаг бол энэхүү озоны давхаргыг гэмтээдэг пестицидээ солихын тулд олон улс оронд ашиглаж буй үр дүнтэй, аюулгүй өөр орлуулах бодисоор солихыг яаравчлаарай. Өөр сонголтууд ч байгаа гэдгийг санааарай. Жишээ нь нэгдсэн менежмент химийн зардалг.м. Хэрэвтаметил бромид ашигладаггүй бол хэзээ ч түүнийг ашиглаж болохгүй шүү. Та ирээдүйд нүүр хийх газаргүй болно шүү гэдгийг санаж яваарай.



ТА ОЗОНД ХАЛГҮЙ ХӨРГӨЛТИЙН ТЕХНИКЧ БАЙЖ ЧАДНА

Агаар сэлгүүр, хөргөгч, хөлдөөгч зэргээс хөргөх бодисыг юүлэхдээ агаарт алдаж болохгүй, вентилээ нээхдээ болгоомжтой байх хэрэгтэй шүү. Засахаас өмнө сайтар шалгаж, ямар нэгэн газраар хөргөх бодис шүүрч алдагдаж байвал юун түрүүнд засварлаарай.



ТА ОЗОНД ХАЛГҮЙ АЛБАН ХААГЧ БАЙЖ ЧАДНА

Танай байгууллагад байгаа ямар тоног төхөөрөмж /тухайлбал ус хөргүүр, агааржуулагч, цэвэрлэгээний уусмал, гал унтраагуур зэрэг/, мөн худалдан авдаг ямар бараа бүтээгдэхүүн

/шүршигч, хөөсний матрас/ озон задалдаг бодис ашигладаг болохыг тодорхойлоход тусла. Зардал хэмнэсэн бусад өөр төрлийн орлуулагч бодисоор солих төлөвлөгөө боловсруулаарай. Та байгууллагынхаа байгаль орчны хамгаалах лидэр ч болж болох шүү дээ.



ТАНАЙХ ОЗОНД ХАЛГҮЙ КОМПАНИ БАЙЖ ЧАДНА

Ажлын байран дээрээ, эсвэл таны үйлдвэрлэлийн процессд ашиглагддаг озон задалдаг бодисоо солих хэрэгтэй. Хэрэв таны бараа бүтээгдэхүүн озон задалдаг бодис агуулдаг бол озоны давхаргыг устгадаггүй бусад орлуулагч бодисыг ашиглахын тулд бүтээгдэхүүнээ өөрчилөөрэй.



ТА ОЗОНД ХАЛГҮЙ БАГШ БАЙЖ ЧАДНА

Та сурагчдадаа байгаль орчноо, тухайлбал озон давхаргыг хамгаалахын ач холбогдлын талаар ярьж бай. Озон задалдаг бодис агаар мандал, хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдөг,

энэ асуудлыг шийдэхийн тулд олон улсын болон улс орны хэмжээнд ямар алхам, үйл ажиллагааг авч хэрэгжүүлж байгаа талаар хичээл заа. Сурагчдыг гэр бүлийнхээ гишүүдэд энэ мэдээллийг харилцан хуваалцаж байхыг зөвлөөрэй.



ТА ОЗОНД ХАЛГҮЙ НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН БАЙЖ ЧАДНА.

Та гэр бүл, хөрш айлууд, найз нөхөддөө озоны давхаргыг хамгаалахын хэрэгцээ шаардлагын талаар ярьж, тэднийг энэ үйлсэд татан оролцуул. Өөрийн хот, тосгон, суурингуудад озон задалдаг бодисыг аажмаар бууруулахын тулд мэдээллийн компанит ажил өрнүүлж, техникийн туслалцаа үзүүлж чадах төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаарай.



ТА ОЗОНД ХАЛГҮЙ ИРГЭН БАЙЖ ЧАДНА

Озон задалдаг бодисын тухай Монреалийн протоколыг хэрэгжүүлэхийн тулд озоны хомсдол хүн ард, ан амьтан, байгаль орчин, танай улсын үндэсний стратеги, бодлогод үзүүлж болох хор уршгийн талаар,

озон задалдаг бодисыг аажмаар бууруулах

гэдэг нь танай орны хувьд юу гэсэн үг болох талаар уншиж судал, суралц. БОАЖЯ-ны

Озон үндэсний албатай харилцаа холбоотой байж, хувь хүний, иргэний хувьд озон давхаргыг хамгаалах ажилд хэрхэн хувь нэмэр оруулж, гар биеэр оролцож болох талаар судлаарай.



Та цаашдаа нүүрс устөрөгч (R600a, R290, R32, R1234yf, R717, R744)-ийн төрлийн бодис агуулсан озоны давхарга, уур амьсгалд ээлтэй тоног төхөөрөмж худалдан авч байхыг зөвлөж байна.

ХӨРГӨЛТ, АГААРЖУУЛАЛТЫН ТӨХӨӨРӨМЖИД ТҮГЭЭМЭЛ ХЭРЭГЛЭДЭГ ХӨРГӨХ БОДИСУУД

Төхөөрөмжийн төрөл	ДДНЧ* дунд/багатай орлуулах бодис	ДДНЧ* өндөртэй орлуулах бодис
Ахуйн хөргөгч, хөлдөөгч	R-600a (Изо-бутан)	R-134a (HFC-134a)
Худалдаа, нийтийн хоолны хөргөх төхөөрөмж	R-290 (Пропан) R-744 (CO ₂)	R-134a (HFC-134a) R-404A (HFC-хольц)
Тасалгааны агааржуулагч төхөөрөмж	R-32 (HFC-32) R-290 (Пропан)	R410A (HFC-хольц)

*ДДНЧ - Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар

ХӨРГӨХ БОДИСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АНГИЛАЛ

АНГИЛАЛ	АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БҮЛЭГ	
	А ХОРТ ШИНЖ ЧАНАР БАГА	В ХОРТ ШИНЖ ЧАНАР ИХ
1 Шатамхай бус	A1 Жишээ нь: R-22, R-134a, R-410A, R-404A, R-407C, R-744(CO ₂)	B1  Жишээ нь: R-123
2L Бага зэргийн шатамхай 	A2L Жишээ нь: R-32, R-1234yf	B2L  Жишээ нь: R-717 (Аммиак)
2 Шатамхай 	A2 Жишээ нь: R-152a	B2 
3 Их шатамхай 	A3 Жишээ нь: R-290 (Пропан), R-600a (Изо-бутан)	B3 

*ISO-817 : Refrigerants-designation and safety classification (Хөргөх бодисын нэршил, аюулгүй байдлын ангиллын стандарт)



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ,
ОЗОНЫ ҮНДЭСНИЙ АЛБА

Улаанбаатар хот 15160,
Чингэлтэй дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө-4,
Экспресс цамхаг, 304 тоот



+976-11-312458



mongolia@ozone.mn



NOA Mongolia